| Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/ | | |
|---|---|---|
| *Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.* | | |
| | | |
| *Тайлагнах хугацаа* | | 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | | Компанийн нэр: Айтүүлс ХК<br>УБГД: 9010001141<br>Үнэт цаасны код: 543<br>Утас: 75755585<br>Имэйл: info@itools.mn<br>Фэйсбүүк: Айтүүлс ХК |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | | Монголын хөрөнгийн бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | | Мэдээллийн технологи, харилцаа холбоо |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | | 34,452,124 |
| *Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | | Нягтлан бодогч Б.Өнөрбадрах |
| | | |
| *1.* | *Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/* | |
| | *Санхүүгийн байдлын үзүүлэлт* | Хагас жилийн санхүүгийн нэгдсэн тайланг Нэгдүгээр хавсралтаар хавсаргав. |
| | *Орлогын тайлан* | |
| | *Өмчийн өөрчлөлтийн тайлан* | |
| | *Мөнгөн гүйлгээний тайлан* | |

| | | |
|---|---|---|
| | | |
| 2. | *Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт* | |
| | Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит хурлаар Айтүүлс ХК-ийн 2022 оны нэгдүгээр хагас жилийн тайланг хэлэлцэн батална. | |
| 3. | *Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт* | |
| 3.1. | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | |
| 3.2. | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | |

| | |
|---|---|
| Цэвэр ашгийн хувь | 1% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 0.1% |
| Нийт хөрөнгийн өгөөж | 0.2% |
| Нэгж хувьцаанд ногдох ашиг | 0.49 |
| Эргэлтийн харьцаа | 2.4 |
| Түргэн хөрвөх чадварын харьцаа | 1.8 |

| | | |
|---|---|---|
| 3.3. | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл* | Үйл ажиллагааны тайланг хоёрдугаар хавсралтаар хавсаргав. |
| 3.4. | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого* | Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй. |
| 4. | *Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/* | |
| | Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдээгүй болно. | |
| 5. | *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл* | |

Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй болно.

5. *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*

***Хувьцаа эзэмшигчдийн бүтэц***







**КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 21/025 тоот тогтоолоор 2022 онд байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталж нийт 3 хэлтэс, 7 хэсэг нийт 27 ажлын байртайгаар үйл ажиллагаа явуулахыг баталсан. Тус бүтэц, орон тоог Дархан хотын дата төв болон олон улсын TIER III дата төвүүд ашиглалтад орсноор тооцон баталсан болно.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд:**

1. ТУЗ-ийн дарга Г.Хатанболд
   ТУЗ-ийн ердийн гишүүн А. Баттамир
   ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Амгаланбаатар
   ТУЗ-ийн ердийн гишүүн Н.Улаанхүү
   ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Даваа
   ТУЗ-ийн ердийн гишүүн Б.Тамир
   ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Гантуяа
   ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Жавхлан
   ТУЗ-ийн хараат бус гишүүн З.Саранчимэг

Айтүүлс ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Бизнес хөгжлийн хороо нь компанийн “Бизнес төлөвлөгөө” боловсруулахад болон компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, борлуулалт стратеги төлөвлөлт дээр Гүйцэтгэх удирдагад зөвөлгөө өгч дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

6. *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*

Айтүүлс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуульд заасны дагуу аудитын, цалин, урамшууллын нэр дэвшүүлэх хороодоос гадна Мэдээллийн аюулгүй байдлын болон Бизнес хөгжлийн хороог дэргэдээ байгуулан ажиллаж байна. Мөн компанид үр ашигтай шийдвэр гаргах, компанийн үйл ажиллагааг хянах болон бодлого, стратегийг тодорхойлох, Гүйцэтгэх удирдлагад стратегийн удирдамж чиглэлээр ханган ажиллаж байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

| | |
|---|---|
| Овог, нэр: Чимэдхишигийн Мөнхжаргал<br><br>Албан тушаал: "Айтүүлс" ХК-ийн Гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ........................................<br>(Тамга/тэмдэг)<br><br>УЛААНБААТАР ХОТ<br>itools<br>АЙТҮҮЛС<br>1116218269 … 5468361 | Овог, нэр: ..............................................<br><br>Албан тушаал: "....." ..К аудитын компанийн гүйцэтгэх захирал<br><br>Гарын үсэг: ..........................................<br>(Тамга/тэмдэг) |

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Янжинлхам

Албан тушаал: Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ..............................................

# ХАВСРАЛТ №1

Сангийн сайдын 2012 оны
... дугаар тушаалын
3 дугаар хавсралт

Регистрийн дугаар: 5468361

Хаяг : Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Реженси Резиденс ХХК

Шуудангийн хаяг : info@itools.mn

Утас : 75755585 Факс :

Өмчийн хэлбэр : Төрийн . . . . . хувь хувийн 100 хувь.

**АЙТҮҮЛС ХК-ИЙН**
**2022 ОНЫ 2-Р УЛИРАЛЫН**
**САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

| | **Сар, өдөр** | **Гарын үсэг** |
|---|---|---|
| | | |
| | | |
| | | |
| | | |

Айтүүлс ХК

# Санхүү байдлын тайлан

Тайлант үе: 2022/01/01 - 2022/06/30

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ХӨРӨНГӨ** | **0.00** | **0.00** |
| 1.1 | **Эргэлтийн хөрөнгө** | **0.00** | **0.00** |
| 1.1.1 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 250,132,657.85 | 240,069,922.02 |
| 1.1.2 | Дансны авлага | 518,226,897.46 | 546,417,522.82 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 0.00 | 288,189.16 |
| 1.1.4 | Бусад авлага | 29,664,162.05 | 72,268,968.00 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.6 | Бараа материал | 114,587,989.19 | 146,307,758.33 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал тооцоо | 113,045,953.00 | 7,764,489.39 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 0.00 | 0.00 |
| 1.1.10 | ... | 0.00 | 0.00 |
| 1.1.11 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **1,025,657,659.55** | **1,013,116,849.72** |
| 1.2 | **Эргэлтийн бус хөрөнгө** | **0.00** | **0.00** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 3,497,288,616.25 | 3,476,631,490.34 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 45,443,051.07 | 32,261,870.72 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 70,446,145.00 | 70,446,145.00 |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.7 | Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.9 | ... | 0.00 | 0.00 |
| 1.2.10 | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **3,613,177,812.32** | **3,579,339,506.06** |
| 1.3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,638,835,471.87** | **4,592,456,355.78** |
| 2 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **0.00** | **0.00** |
| 2.1 | **ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **0.00** |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | **0.00** | **0.00** |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 115,806,636.07 | 11,061,759.00 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 0.00 | 279,815.00 |
| 2.1.1.3 | Татварын өр | 22,141,375.74 | 58,910,740.87 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 0.00 | 0.00 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 0.00 | 4,576,000.00 |
| 2.1.1.9 | Нөөц / өр төлбөр / | 0.00 | 0.00 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 0.00 | 0.00 |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )- нд хамаарах өр төлбөр | 0.00 | 0.00 |
| 2.1.1.12 | ... | 0.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2.1.1.13 | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **137,948,011.81** | **74,828,314.87** |
| 2.1.2 | **Урт хугацаат өр төлбөр** | **997,000,000.00** | **997,000,000.00** |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 997,000,000.00 | 997,000,000.00 |
| 2.1.2.2 | Нөөц / өр төлбөр/ | 0.00 | 0.00 |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 0.00 | 0.00 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 0.00 | 0.00 |
| 2.1.2.5 | ... | 0.00 | 0.00 |
| 2.1.2.6 | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **997,000,000.00** | **997,000,000.00** |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | **1,134,948,011.81** | **1,071,828,314.87** |
| 2.3 | Эздийн өмч | 0.00 | 0.00 |
| 2.3.1 | Төрийн өмч | 0.00 | 0.00 |
| 2.3.2 | Хувийн өмч | 1,481,441,363.28 | 1,481,441,363.28 |
| 2.3.3 | Хувьцаат өр төлбөр | 0.00 | 0.00 |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | 0.00 | 0.00 |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 763,114,860.00 | 763,114,860.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 460,721,652.19 | 460,721,652.19 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | 0.00 | 0.00 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 0.00 | 0.00 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 798,609,584.59 | 815,350,165.44 |
| 2.3.10 | ... | 0.00 | 0.00 |
| 2.3.11 | **Эздийн өмчийн дүн** | **3,503,887,460.06** | **3,520,628,040.91** |
| 2.4 | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **4,638,835,471.87** | **4,592,456,355.78** |

Гүйцэтгэх захирал ............................................... Б.Тамир

Нягтлан бодогч ............................................... Б.Өнөрбадрах

Айтүүлс ХК

# Орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант үе: 2022/01/01 - 2022/06/30

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого ( цэвэр )** | **2,546,825,167.74** | **1,700,810,460.01** |
| 2 | Борлуулалтын өртөг | 1,574,491,854.53 | 1,006,984,368.72 |
| 3 | **Нийт ашиг ( алдагдал )** | **972,333,313.21** | **693,826,091.29** |
| 4 | Түрээсийн орлого | 20,681,818.19 | 33,454,545.46 |
| 5 | Хүүгийн орлого | 0.00 | 0.00 |
| 6 | Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| 8 | Бусад орлого | 4,000,000.00 | 0.00 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 0.00 | 0.00 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 931,434,739.58 | 707,045,379.10 |
| 11 | Санхүүгийн зардал | 0.00 | 0.00 |
| 12 | Бусад зардал | 18,838,705.67 | 1,547,375.00 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз ( гарз ) | 1,506,388.44 | 84,693.29 |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | 0.00 | 0.00 |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз ( гарз ) | 0.00 | 0.00 |
| 16 | Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз ( гарз ) | 0.00 | 0.00 |
| 17 | Бусад ашиг ( алдагдал ) | 0.00 | 0.00 |
| 18 | **Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )** | **48,248,074.59** | **18,772,575.94** |
| 19 | Орлогын татварын зардал | 6,708,678.03 | 2,031,995.09 |
| 20 | **Татварын дараах ашиг ( алдагдал )** | **41,539,396.56** | **16,740,580.85** |
| 21 | **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг ( алдагдал )** | **0.00** | **0.00** |
| 22 | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )** | **41,539,396.56** | **16,740,580.85** |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 |
| 23.1 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 23.2 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 |
| 23.3 | Бусад олз ( гарз ) | 0.00 | 0.00 |
| 24 | **Орлогын нийт дүн** | **41,539,396.56** | **16,740,580.85** |
| 25 | **Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг ( алдагдал )** | **0.00** | **0.00** |

Гүйцэтгэх захирал ................................................ Б.Тамир

Нягтлан бодогч ................................................ Б.Өнөрбадрах

Айтүүлс ХК

# Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант үе: 2022/01/01 - 2022/06/30

| | Үзүүлэлт | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,481,441,363.28 | 0.00 | 763,114,860.00 | 460,721,652.19 | 0.00 | 0.00 | 757,070,188.03 | **3,462,348,063.50** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| 3 | Залруулсан үлдэгдэл | 1,481,441,363.28 | 0.00 | 763,114,860.00 | 460,721,652.19 | 0.00 | 0.00 | 757,070,188.03 | **3,462,348,063.50** |
| 4 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| 5 | Өмчид гаргасан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| 6 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| 7 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 41,539,396.56 | **41,539,396.56** |
| 8 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| 9 | 2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 1,481,441,363.28 | 0.00 | 763,114,860.00 | 460,721,652.19 | 0.00 | 0.00 | 798,609,584.59 | **3,503,887,460.06** |
| 10 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| 11 | Залруулсан үлдэгдэл | 1,481,441,363.28 | 0.00 | 763,114,860.00 | 460,721,652.19 | 0.00 | 0.00 | 798,609,584.59 | **3,503,887,460.06** |
| 12 | Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| 13 | Өмчид гаргасан өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| 14 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| 15 | Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал ) | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 16,740,580.85 | **16,740,580.85** |
| 16 | Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| 17 | 2022 оны 6-р сарын 30-ээрх үлдэгдэл | 1,481,441,363.28 | 0.00 | 763,114,860.00 | 460,721,652.19 | 0.00 | 0.00 | 815,350,165.44 | **3,520,628,040.91** |

Гүйцэтгэх захирал ..................................................... Б.Тамир

Нягтлан бодогч ..................................................... Б.Өнөрбадрах

Айтүүлс ХК

# Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант үе: 2022/01/01 - 2022/06/30

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | Тайлант үеийн дүн | Өссөн дүн |
|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | **1,792,722,742.42** | **1,792,722,742.42** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого | 1,761,922,742.42 | 1,761,922,742.42 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 0.00 | 0.00 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | 0.00 | 0.00 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 0.00 | 0.00 |
| 1.1.6 | Бусад мөнгөн орлого | 30,800,000.00 | 30,800,000.00 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **1,589,656,851.68** | **1,589,656,851.68** |
| 1.2.1 | Ажилагсад төлсөн | 195,058,380.34 | 195,058,380.34 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 57,399,670.43 | 57,399,670.43 |
| 1.2.3 | Лиценц, RC сунгалт, Датакомд төлсөн | 335,993,582.17 | 335,993,582.17 |
| 1.2.4 | Тендерт төлсөн | 314,834,478.07 | 314,834,478.07 |
| 1.2.5 | Мэргэжлийн үйлчилгээний зардалд төлсөн | 90,995,317.00 | 90,995,317.00 |
| 1.2.6 | Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 300,000.00 | 300,000.00 |
| 1.2.7 | Ашиглалтын зардалд төлсөн | 133,076,427.63 | 133,076,427.63 |
| 1.2.8 | Хүүний төлбөрт төлсөн | 119,640,000.00 | 119,640,000.00 |
| 1.2.9 | Татварын байгууллагад төлсөн | 73,818,861.71 | 73,818,861.71 |
| 1.2.10 | Даатгалын төлбөрт төлсөн | 0.00 | 0.00 |
| 1.2.11 | Бусад мөнгөн зарлага | 268,540,134.33 | 268,540,134.33 |
| 1.3 | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | **172,265,890.74** | **172,265,890.74** |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | **147,661,893.91** | **147,661,893.91** |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсаны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө боруулсаны орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 147,661,893.91 | 147,661,893.91 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 0.00 | 0.00 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **248,133,652.43** | **248,133,652.43** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 132,925,652.43 | 132,925,652.43 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 115,208,000.00 | 115,208,000.00 |
| 2.3 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-100,471,758.52** | **-100,471,758.52** |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 2,816,222.85 | 2,816,222.85 |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 0.00 |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | 0.00 | 0.00 |
| 3.1.4 | Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг | 2,816,222.85 | 2,816,222.85 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | **84,673,090.90** | **84,673,090.90** |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 81,941,561.34 | 81,941,561.34 |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 0.00 | 0.00 |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдаж төлсөн | 0.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| 3.2.5 | Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал | 2,731,529.56 | 2,731,529.56 |
| 3.3 | Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн | -81,856,868.05 | -81,856,868.05 |
| 4 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | -10,062,735.83 | -10,062,735.83 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | **250,132,657.85** | **250,132,657.85** |
| 6 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | **240,069,922.02** | **240,069,922.02** |

Гүйцэтгэх захирал ............................................... Б.Тамир

Нягтлан бодогч ............................................... Б.Өнөрбадрах

# ХАВСРАЛТ №2

# 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

itools.mn 7575 5585

# АГУУЛГА


## 01 КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ

Компанийн алсын хараа, үнэт зүйл

ТУЗ-ын гишүүдийн танилцуулга

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

## 02 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022 оны хагас жилийн үйл ажиллагааны товч тайлан

2022 оны төлөвлөгөө, зорилго зорилтууд

# КОМПАНИЙН ТУХАЙ

Манай компани нь Монгол Улсад мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр 2011 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 2012 оноос эхлэн домэйн нэрийн бүртгэл, веб хост, сервер байршуулалт, виртуал серверийн түрээс, и-мэйл сервисийн ашиглалт зэрэг интернет технологид суурилсан бүтээгдэхүүн, үйчилгээг аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүст үзүүлж тэдгээрийн тасралтгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажилласаар ирсэн. Компани нь өнгөрсөн 11 жилийн хугацаанд мэдлэг чадвартай ажилтан, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нийлүүлэн салбарынхаа тэргүүлэх компани болохыг зорьж ажилласан ба 2017 оны 09 сараас эхлэн өмчийн хэлбэрээ өөрчлөн, хувьцаат компани болсон.

## Компанийн алсын хараа, үнэт зүйл

### Алсын хараа:

*Дэлхийн жишиг дата төв болж бүтээгдэхүүн үйлчилгээгээ дэлхийд экспортлоно.*

### Эрхэм зорилго:

*Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхолыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.*




### Эрхэмлэх үнэт зүйлс:

- *Компани төдийгүй эх орныхоо төлөө бие сэтгэл, мэдлэг чадвараа бүрэн дайчлан ажиллаж буй бизнесийн ёс зүйтэй баг, хамт олон*
- *Мэдээллийн технологи, өгөгдлийн үнэ цэнийг ойлгож үргэлж хамт байдаг хэрэглэгч, харилцагч, бизнесийн түншүүд*
- *Дэлхийд чанараар өрсөлдөх бүтээгдэхүүн, үйлчилгээ*
- *Харилцагчийн мэдээллийн аюулгүй байдал*

### Үйл ажиллагааны зарчим:

- *Ёс суртахуунтай, ил тод, нээлттэй*
- *Хууль, эрх зүйн хэм хэмжээг дээдлэнэ*
- *Мэдээллийн аюулгүй байдлыг чандлан сахина*

## ТУЗ-ийн бүрэлдэхүүн



**ТУЗ-ийн дарга**

**Г.Хатанболд**

Санхүүгийн удирдлагын магистр

“Ай Си Ти Групп” ХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал



**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Г.Гантуяа**

Бизнесийн удирдлагын докторант

Номадик контент ХХК-ийн үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирал



**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Н.Жавхлан**

Бизнесийн удирдлага, Төрийн удирдлагын магистр

Могул Консалтинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал



**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**З.Саранчимэг**

Эрх зүйн ухааны магистр

Ачтан эмнэлэгийн Хүний нөөцийн менежер



**ТУЗ-ийн ердийн гишүүн**

**А.Баттамир**

Техникийн ухааны магистр

Ай Си Ти групп ХК-ийн үүсгэн байгуулагч



**ТУЗ-ийн ердийн гишүүн**

**Б.Амгаланбаатар**

Нягтлан бодогч

Ай Си Ти групп ХК-ийн Санхүү хариуцсан захирал



**ТУЗ-ийн ердийн гишүүн**

**Н.Улаанхүү**

Эдийн засгийн онолч, эдийн засагч

Ай Си Ти групп ХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал



**ТУЗ-ийн ердийн гишүүн**

**Б.Тамир**

Улс төрийн удирдлагын магистр

Ай Си Ти групп ХК-ийн Хамтын ажиллагаа, борлуулалт маркетингийн газрын захирал



**ТУЗ-ийн ердийн гишүүн**

**Д.Даваа**

Програм хангамжийн инженер

Ай Си Ти групп ХК-ийн төлбөр тооцоо хариуцсан



**ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**

**Г.Янжинлхам**

Нийтийн удирдлага магистр, эрх зүйч

*Хувьцаа эзэмшигчдийн бүтэц*







## КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Компанийн ТУЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 21/025 тоот тогтоолоор 2022 онд байгууллагын бүтэц, орон тоог шинэчлэн баталж нийт 3 хэлтэс, 7 хэсэг нийт 27 ажлын байртайгаар үйл ажиллагаа явуулахыг баталсан. Тус бүтэц, орон тоог Дархан хотын дата төв болон олон улсын TIER III дата төвүүд ашиглалтад орсноор тооцон баталсан болно.

# 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

## ДЭД БҮТЭЦ САЙЖРУУЛАЛТ



### Улаанбаатар дата төвийн 2 -р давхрын серверийн өрөөг ашиглалтад оруулах

Улаанбаатар хотын санхүүгийн дата төвийн байрны 2-р давхрыг серверийн өрөөний стандартын дагуу засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Дэд бүтэц, тоног төхөөрөмжийн захиалга, суурилуулалтын ажил хийгдсэн. Тог баригч төхөөрөмжийн суурилуулатын ажлыг дуусгаж, 8-р сарын 15 - ны өдрөөр бүрэн ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

### Үндсэн бүтээгдэхүүн үйлчилгээний сервер, сүлжээ, backup-н шийдлийг шинэчлэх

Шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа болон технологийн шийдлийг боловсруулж дууссан. Тоног төхөөрөмжийн худалдан авалтын эхний ээлжийн захиалгыг хийсэн. Уг шинэчлэлтийг хийснээр голлох бүтээгдэхүүн үйлчилгээнүүд болох Дундын хостын үйлчилгээ, болон Бизмэйл үйлчилгээний серверүүдийн хүчин чадал дараах байдлаар нэмэгдэхээр тооцоологдож байна.

Хардны бичилтийн хурд : 10 дахин нэмэгдэнэ<br>
Сүлжээний хурд : 10 дахин нэмэгдэнэ<br>
Нөөцлөлт хийх хугацаа : 3 дахин хурдасна<br>
Санах ойн хурд : 2 дахин нэмэгдэнэ

### ITOOLS.mn сайтын шинэчлэлт

Компанийн веб сайтын шинэчлэлт, хэрэглэгчийн системийн шинэчлэлтийг “Ай си ти групп” ХК– тай хамтран хийж дууссан. 2022.08.01–ний өдөр шинэ сайтруу шилжиж, ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

### Cloud DDOS protection болон интернэтийн 2 дахь эх үүсвэрийг холбох ажил

2021.03.21-ний өдрөөс 2022.03.23-ны өдрүүдэд Улаанбаатар хотын дата төвийн гадаад урсгалыг чиглэсэн их хэмжээний DDOS халдлага орж ирсэн. ЖиНет ХХК – тай хамтран Cloud DDOS protection – ийн холболтын ажлыг тохируулсан ба гэрээ байгуулж интернэтийн бөөний урсгал авч, нэг жилийн хугацаатай clean internet үйлчилгээ авсан бөгөөд Мобиком Нетворкс ХХК – тай хийсэн гэрээг шинэчлэн нөөц урсгалаар тохируулсан. Ингэснээр Айтүүлс ХК – ийн дата төв 2 интернэтийн урсгалтай, cloud DDOS protection – зэрэг 2 гол асуудлыг шийдэх боломжтой болсон.

### Дотоод CRM системийг нэвтрүүлэх

Crm.itools.mn - системийн нэвтрүүлэлт, хөгжүүлэлтэд зөвлөх “Би Эксперт Клаудс” ХХК компанитай хамтран, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж ашиглалтад оруулсан.

### cloud.mn үйлчилгээний өргөтгөлийн ажил

Cloud.mn үйлчилгээний өргөтгөлийн ажил дээр сүлжээний холболтын ажил дээр “Фибо Клауд” ХХК-тай хамтран ажиллаж, ашиглалтад оруулсан.

## ДАТА ТӨВИЙН UPTIME /найдвартай ажиллагаа/

Улаанбаатар хотын Дата төв 99.999 %-н uptime тай ажилласан

Uptime : 99.999%

Downtime : 0.001%

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Report Time Span: | 1/1/2022 12:00:00 AM - 6/30/2022 12:00:00 AM | | | | | |
| Sensor Type: | SNMP Traffic 64bit (60 s Interval) | | | | | |
| Probe, Group, Device: | Local probe > 1st group > CISCO-ROUTER | | | | | |
| Uptime Stats: | Up: | 99.999 % | [179d4h35m49s] | Down: | 0.001 % | [3m30s] |
| Request Stats: | Good: | 99.987 % | [258057] | Failed: | 0.013 % | [34] |
| Average (Traffic Total): | 423 Mbit/s | | | | | |
| Total (Traffic Total): | 781,578,107 MByte | | | | | |

## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**SPOT** Брэндингийн агентлагтай хамтран ажиллах гэрээ байгуулж сошиал сувгийн хөтлөлт болон фото, видео контент хийж хамтран ажиллаж байна.



Радио рейтингээр хамгийн олон сонсогчидтой **MGL радио**-н оргил цагуудаар 3 нэвтрүүлэг сонгон орон даяар бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл бүхий идэвхжүүлэлтийн ажил хийгдсэн.

Бизнесийн олон салбарт амжилттай ажиллаж байгаа 80 байгууллагыг урьж **CLOUD event** зохион байгуулж үйл ажиллагаа бүтээгдэхүүн үйлчилгээний талаар танилцуулга хийгдсэн.

## 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗОРИЛГО ЗОРИЛТУУД

### Зорилго:

*Айтүүлс ХК нь 2022 оны үйл ажиллагаанд дараах зорилтуудыг тавьж ажиллахаар төлөвлөсөн.*




## КОМПАНИЙН ҮНЭ ЦЭНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

- Компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд Радио рейтингээр хамгийн олон сонсогчидтой MGL 88,3 радио-н оргил цагуудаар 3 нэвтрүүлэг сонгон орон даяар бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдээлэл бүхий идэвхжүүлэлтийн ажил хийгдсэн. /давтагдсан тоогоор 673.000 хүнд хүрсэн/
- Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа дундын оффисуудтай хамтран ажиллаж бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилах ажлыг тогтмол хийхээр хамтран ажиллах бэлтгэл хангагдаж байна.
- Бүтээгдэхүүн үйлчилгээний анхан шатны мэдээлэл бүхий тайлбар видео контентууд хийж сошиал орчинд хэрэглэгчдэд хүргэж эхэлсэн.

## ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ

- Хэрэглэгчийн сэтгэл ханамжийг сайжруулахын тулд тулгамдаж байгаа асуудлаа тодорхойлохын тулд хөндлөнгийн мэргэжлийн байгууллага болох “Би Эксперт Клаудс” ХХК-тай хийгдсэн гэрээний дагуу хэрэглэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авч хамтран ажилласан бөгөөд уг судалгаанд тулгуурлан төлөвлөгөө гарган ажилласан.
- Судалгааны үр дүнд үндэслэн хэрэглэгч үйлчилгээний талаар мэдээлэл болон үйлчилгээ авахад хялбар ойлгомжтой болгож веб сайтыг шинэчилж бэлэн болсон.
- Мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагатай хамтран хэрэглэгчийн санал хүсэлтийг эцэслэн шийдвэрлэх журам баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

## ДОТООД ПРОЦЕСС САЙЖРУУЛАХ

Компанийн дотоод процессыг сайжруулах зорилтын хүрээнд Монголын стандарт чанарын хүрээлэн ТББ-тай “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001”, “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 27001” стандартуудыг тус тус нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээг хийж эхлүүлсэн. Гэрээний хэрэгжилтийг 2022 оны 08 дугаар сараас эхлэн эрчимтэй эхлүүлэхээр төлөвлөөд байна.

Мөн дотоод процесс, үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллах үүднээс нийт ажилтнуудад бүтэн жилийн үйл ажиллагааны гарын авлага мөн шинэ ажилтан дадлагажуулах хөтөлбөр боловсруулсан гэх зэрэг ажлуудыг 2022 оны зорилтуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн байна.

## АЖИЛТНУУДЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ



Ажилтнуудын сэтгэл ханамжийг сайжруулах зорилтын хүрээнд нийт ажилтнуудыг идэвхжүүлэх, дотоод уур амьсгалыг сайжруулах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан бөгөөд “Тархины фитнесс” клубын арга хэмжээг өглөөний сургалт, уулзалтын хэлбэрээр зохион байгуулж эхэлсэн. Мөн ажилтнуудын сайн сайхныг дэмжих бодлогын хүрээнд эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан байна.

Нито ХХК-тай 4 сарын үйлчилгээний гэрээ байгуулсан бөгөөд тус гэрээний хүрээнд “Pure Love” багцийн дагуу 10 ажилтан сэтгэлзүйн зөвлөгөөнд хамрагдсан.

Ажилтнуудын сайн сахныг дэмжих бодлогын хүрээнд нийт ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг, сэтгэлзүйн ганцаарчилсан зөвлөгөөнд хамруулсан нь ажилтнуудын сэтгэл зүй болон эрүүл мэндийн асуудалд тодорхой хэмжээнд анхаарч цаашид ч бодлогын түвшинд хэрэгцээ шаардлагыг тодорхойлон төлөвлөгөөнд тусган ажиллахыг зорьж байна.

## АЖИЛТНУУДЫН УР ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ

Тус зорилтын хүрээнд тогтмол сургалтанд хамрагдаж ажилтнуудыг идэвхжүүлсэн:



- “Би Эксперт Клаудс” ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж гэрээний дагуу тогтмол 8 удаагийн сургалт зохион байгуулагдсан. Мөн тус гэрээний хүрээнд хэрэглэгч үйлчилгээний нийт 2 стандарт, 2 журам албан ёсоор батлуулан журамтай холоотой 2 удаагийн сургалт зохион байгуулсан. */Захиргаа, хүний нөөцийн хэсгээс хамтран ажилласан/*
- Нито ХХК-иас “Pure Love” багц үйлчилгээ авч нийт ажилтнуудад тайлант хугацаанд 2 удаагийн “Багийн дүр тодорхойлох” болон “Ажлаас халшрах өвчнөөс сэргийлэх” сургалтуудыг тус тус зохион байгуулсан.
- ТТҮАХ – н нийт ажилтнууд Фибо Клауд ХХК – ийн Kubernetes  үүлэн технологийн сургалтад бүрэн бүрэлдэхүүнээрээ хамрагдсан.
- 2 ажилтан олон улсын сүлжээний Cisco CCNA - ROUTING & SWITCHING сургалтад хамрагдсан.
- Нийт 6 ажилтан “ISO 27001:2013 standard – Implementation” дотоод аудиторын сургалтад хамрагдаж сертификат авсан.
- Хамтын ажиллагааны хүрээнд ХИЛ ХАМГААЛАХЫН ЕРӨНХИЙ ГАЗАР -ын Мэдээлийн технологийн ажилтан, албан хаагч нарт SNMP технологи болон PRTG програмын сургалт явуулсан.

Тус зорилтуудын хүрээнд 2022 онд харицагч болон хэрэглэгчдээ халамжлах, стандартын дагуу үйлчилгээ үзүүлэх, компанийн дотоод процессыг сайжруулах замаар менежментийн хувьд дэвшилт гаргах зорилготой ажиллаж байна. Ингэснээр компанийн дотоод болон гадаад орчинд үзүүлэх нөлөөллийг сайжруулах зорилготой билээ.

itools.mn
7575 5585